

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянзүрх дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар гурав ОНӨААТҮГ-ын
2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2024/69/НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Гэрээгээр гүйцэтгэсэн: Мэдээлэл Аудит ХХК-ийн захирал: Д.Товуудорж Утас: 9904-9511 Цахим хаяг: medeeleaudit@gmail.com</p> <p>Аудитын менежер: А.Гэрэлмаа Утас: 9949-9667 Цахим хаяг: gerelmaa_69@yahoo.com</p> <p>Аудитор: Д.Туяа Утас: 8811-4488 Цахим хаяг: tuya88999@gmail.com</p> <p>Аудитор: Ц.Отгонжаргал Утас: 9100-8515 Цахим хаяг: medeeleaudit@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024 о. 03. 15 № 544
танай _____-ны № _____-т

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН НИЙТЛЭГ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР ГУРАВ
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА Т.ЭНХЖИН
ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянзүрх дүүргийн нийтлэг үйлчилгээний газар гурав ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Баянзүрх дүүргийн нийтлэг үйлчилгээний газар гурав ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2023 оны 06 сарын 21-ны 72 дугаар тогтоолоор Нийтлэг үйлчилгээний газар гурав ОНӨААТҮГ-ыг татан буулгах тухай шийдвэр гарсан. 2023 оны 9 сарын 30-наар татан буугдаж бүрэн зогссон

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Баянзүрх дүүргийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 25-ны А/829 дүгээр захирамжаар Нийтлэг үйлчилгээний газар гурав ОНӨААТҮГ-ын хөрөнгийн бүртгэл, тооллогыг явуулж хүлээн авах чиг үүрэг бүхий ажлын хэсэг

байгуулагдсан. Ажлын хэсэг хөрөнгийн бүртгэл, тооллогыг явуулж хүлээн авсан ба ажлын хэсгийн тайлан хүлээгдэж байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
А	Б		
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	8,074,653.10	6,080,311.18
1.1.2	Дансны авлага		
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		
1.1.4	Бусад авлага	26,867,818.25	13,598,154.95
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	26,540,728.40	10,543,688.40
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	61,483,199.75	30,222,154.53
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	507,470,885.92	620,665,872.53
1.2.2	Биет бус хөрөнгө	31,249.85	
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	507,502,135.77	620,665,872.53
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	568,985,335.52	650,888,027.06
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	6,088,449.90	12,088,449.90
2.1.1.2	Цалингийн өглөг	766,221.46	
2.1.1.3	Татварын өр	25,239,013.51	74,838,366.26
2.1.1.4	НДШ-ийн өглөг	134,942,767.41	206,623,912.81
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	573,495,241.42	695,030,658.11
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	38,275,085.27	37,551,585.27
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөр	778,806,778.97	1,026,132,972.35
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	778,806,778.97	1,026,132,972.35
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: -төрийн	1,084,100.00	1,084,100.00
2.3.2	-хувийн		
2.3.4	Халаасны хувьцаа		
	Хувьцаат капиталын дүн		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	207,000,000.00	207,000,000.00
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(417,905,543.45)	(583,329,045.29)
2.3.11	Эздийн өмчийн дүн	(209,821,443.45)	(375,244,945.29)
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	568,985,335.52	650,888,027.06

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого	2,758,446,405.00	1,763,763,700.00
2	Борлуулалтын өртөг	2,508,233,900.00	1,793,247,355.90
3	Нийт ашиг алдагдал	250,212,505.00	(29,483,655.90)
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого	2,375,600.00	1,007,320.70
6	Ногдол ашгийн орлого		
7	Бусад орлого / орон нутгийн төсөвт байгууллага, үнэ төлбөргүй хүлээн авсан, тусгай зориулалтын шилжүүлгээс/	24,029,584.33	102,699,583.31
8	Борлуулалт маркетингийн зардал		
9	Ерөнхий ба удирдлагын зардал	298,536,732.30	239,646,749.95
10	Санхүүгийн зардал		
11	Бусад зардал		
12	Гадаад валютын ханшийн зөрүүний олз(гарз)		
13	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз(гарз)		
14	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз(гарз)		
15	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз(гарз)		
16	Бусад ашиг (алдагдал)		
17	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(21,919,042.97)	(165,423,501.84)
18	Орлогын татварын зардал		
19	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	(21,919,042.97)	(165,423,501.84)
20	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
21	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(21,919,042.97)	(165,423,501.84)
22	Бусад дэлгэрэнгүй орлого		
23	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз(гарз)		
24	Орлогын нийт дүн	(21,919,042.97)	(165,423,501.84)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

д/д	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	1,084,100.00	216,791,000.00	(405,777,500.00)	(187,902,400.00)
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			9,791,000.00	9,791,000.00
3	Залруулсан үлдэгдэл	1,084,100.00	216,791,000.00	(395,986,500.00)	(178,111,400.00)
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(21,919,100.00)	(21,919,100.00)
5	Бусад дэлгэрэнгүй орлого				
6	Өмчид гарсан өөрчлөлт		(9,971,000.00)		(9,971,000.00)
7	Зарласан ногдол ашиг				
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
9	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,084,100.00	207,000,000.00	(417,905,543.45)	(209,821,443.45)
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
11	Залруулсан үлдэгдэл	1,084,100.00	207,000,000.00	(417,905,543.45)	(209,821,443.45)
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(165,423,501.84)	(165,423,501.84)
13	Бусад дэлгэрэнгүй орлого				
14	Өмчид гарсан өөрчлөлт				
15	Зарласан ногдол ашиг				
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
17	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,084,100.00	207,000,000.00	(583,329,045.29)	(375,244,945.29)

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	Мөнгөн орлогын дүн	2,758,381,705.99	1,777,801,620.70
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	2,250,000,000.00	1,553,763,700.00
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Туслах үйл ажиллагааны орлого	142,335,300.99	14,037,920.70
	Бусад мөнгөн орлого	366,046,405.00	210,000,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн	2,879,603,569.84	1,779,795,962.62
	Ажиллагчдад төлсөн	805,614,176.61	594,210,370.80
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	188,333,872.76	117,523,123.90
	Бараа материал худалдан авахад төлсөн	137,458,315.00	55,007,740.00
	Ашиглалтын зардал төлсөн	54,807,376.75	5,363,101.65
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	818,603,016.75	654,528,770.20
	Хог орлогын төвлөрүүлэх шилжүүлэг	140,001,064.73	2,913,500.00
	Татварын байгууллагад төлсөн	2,986,000.00	1,061,456.07
	Даатгалын төлбөрт төлсөн	1,595,025.00	1,560,600.00
	Бусад мөнгө зарлага	730,204,722.24	347,627,300.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(121,221,863.85)	(1,994,341.92)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн		
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого		
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн		
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн		
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн		
	Зээл, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Вальютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(121,221,863.85)	(1,994,341.92)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	129,296,516.95	8,074,653.10
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,074,653.10	6,080,311.18

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөг/

№	Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	Тайлант оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Нийт санхүүжилт	2,784,851,589	2,210,000,000	1,867,470,604	(342,529,396)	(15)
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,250,000,000	2,000,000,000	1,553,763,700	(446,236,300)	(22)
	Татварын бус орлого	534,851,589	210,000,000	313,706,904	103,706,904	49
2	Нийт зардал	2,802,440,285	2,210,000,000	2,032,894,106	(177,105,894)	(8)
3	Цалин	901,076,251	840,000,000	728,832,025	(111,167,975)	(13)
4	НДШ зардал	131,297,989	121,800,000	106,329,810	(15,470,190)	(13)
5	Гэрэл цахилгаан	1,429,429	1,629,729	1,570,225	(59,504)	(4)
6	Түлш халаалт				-	
7	Цэвэр бохир	3,682,948	3,686,520	3,792,877	106,356	3
8	Байрны түрээс	62,179,000			-	
9	Бичиг хэрэг	3,455,596	3,455,596	2,856,795	(598,801)	(17)
10	Тээвэр, шатахуун	340,380,926	350,000,000	318,808,630	(31,191,370)	(9)
11	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,289,100	38,400,000		(38,400,000)	(100)
12	Аж ахуйн материал худалдан авах зардал	135,451,643	42,000,000	52,446,750	10,446,750	25
13	Нормативт зардал	18,552,689	6,500,000	7,960,000	1,460,000	22
14	Багаж, техник, хэрэгсэл	454,328,008	350,000,000	340,547,875	(9,452,125)	(3)
15	Урсгал засвар				-	
16	Хөдөлмөр хамгааллын зардал	5,531,250	6,000,000		(6,000,000)	(100)
17	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	692,420,269	322,528,155	358,362,856	35,834,701	11
18	Бараа жил үйлчилгээний бусад зардал	25,576,738	125,000,000	110,586,263	(14,413,737)	(12)
19	Элэгдлийн зардал	-			-	
20	Бусад урсгал шилжүүлэг	17,700,000	5,000,000	800,000	(4,200,000)	(84)
21	Төвөлрүүлэн шилжүүлэх	6,088,450			-	
22	Нийт ашиг, алдагдал	(17,588,696)	-	(165,423,502)	(165,423,502)	
23	Татварын зардал	(4,330,347)				
24	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	(21,919,043)	-	(165,423,502)	(165,423,502)	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9,322.9 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч 2 зөвлөмж хүргүүлэв.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Дд	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Тендер зарласан боловч оролцогч байхгүй шалтгаанаар дахин зарлаагүй шууд худалдан авалт хийсэн.	1						1					
2	Тээврийн хэрэгслийн элэгдлийн зардал дутуу тайлагнасан	1	9,322.9					1	9,322.9				
	Дүн	2	9,322.9					2	9,322.9				

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.